

Та бүхэнд 2024 оны 5-р сард батлагдсан онцлох хууль, УИХ-ын болон Засгийн Газрын тогтоол, Нийслэлийн засаг даргын захирамжийг танилцуулж байна.

Батлагдсан хууль

- ❖ 2024 оны 5-р сарын 16-ны өдөр батлагдсан Татварын суурийг багасгах тухай олон талт конвенцыг соёрхон батлах тухай хууль

Тус хуулийн гол зорилго нь “Гуравдагч улсын хөрөнгө оруулагч давхар татварын гэрээг урвуулан ашиглах буюу гэрээний сүлжээ дамжуулан татвараас зайлсхийх асуудлыг хязгаарлах зорилготой юм.” Уг хуулийн нь 2 зүйлтэй бөгөөд:

1 дүгээр зүйлд “Татварын суурийг багасгах, ашиг шилжүүлэх явдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор татварын гэрээтэй холбоотой арга хэмжээг хэрэгжүүлэх тухай олон талт конвенц”-ыг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон батлахаар тусгасан бөгөөд 2 дугаар зүйлд Конвенцод заасан сонголт бүхий зүйлүүдээс алийг сонгож хэрэглэхийг тусгасан байна.

- ❖ 2024 оны 6-р сарын 4-ний өдөр батлагдсан “НҮБ-ын төрөлжсөн байгууллагын эрх ямба, дархан эрхийн тухай конвенц” -ын XV хавсралтыг соёрхон батлах тухай хууль

Бусад 5-р сард гарсан хуулийн төсөл, нэмэлт өөрчлөлтийг энэ QR кодыг уншуулж танилцана уу



Батлагдсан УИХ-ын тогтоол

- ❖ 2024 оны 05 сарын 16 өдрийн, Авлигатай тэмцэх газрын албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай №47 тогтоол.

Тогтоолоор баталсан авлигатай тэмцэх газрын албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээ:

Д/д	Албан тушаал	Албан тушаалын цалингийн хэмжээ /төгрөгөөр/
1	Авилгатай тэмцэх газрын дарга	4 772 128
2	Авилгатай тэмцэх газрын дэд дарга	4 445 241
3	Хэлтсийн дарга	4 261 658
4	Албаны дарга	4 037 154
5	Ахлах ажилтан	3 842 702
6	Ажилтан	3 622 339
7	Туслах ажилтан	2 069 067

- ❖ 2024 оны 04 сарын 18 өдрийн Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр батлах тухай №27 тогтоол
- ❖ 2024 оны 05 сарын 02 өдрийн Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэл, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2023 оны тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай №37 тогтоол

Батлагдсан Засгийн газрын тогтоол

- ❖ 2024 оны 05 сарын 01 өдрийн Багшийн гурван тулгуурт бодлого" цогц арга хэмжээг батлах тухай №192 тогтоол.

"Багшийн гурван тулгуурт бодлого"-ын зорилго нь сургуулийн өмнөх, ерөнхий боловсрол, мэргэжлийн болон техникийн боловсролын багшийн хүртээмжийг нэмэгдүүлэх, чанарыг сайжруулах, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх юм.

- ❖ 2024 оны 05 сарын 15 өдөр, "Хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан тусгай тоноглол бүхий спорт цогцолбор" барьж, байгуулах ажлын талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай №216 тогтоол.

Уг спорт цогцолборыг барьж, байгуулах ажлыг Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хорооны Ажлын албанд даалгаж өгсөн байна.

Нийслэлийн засаг даргын захирамж

- ❖ 2024 оны 05 сарын 31-ний Нийслэлийн төр, захиргааны байгууллагуудын ажлын цагийн хуваарьт зохицуулалт хийх тухай А/630 дугаар захирамж

Нийслэлийн авто замын ачааллыг бууруулах, албан хаагчдын ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх, амралт чөлөөт цагийг зохицуулах зорилгоор хавсралтад заасан нийслэлийн төр, захиргааны байгууллагуудын ажил эхлэх, дуусах цагийг жил бүрийн

6 сарын 01-ээс 8 сарын 31-ний хүртэл 07:00-16:00, 9 сарын 01-ээс 6 сарын 01-ний хүртэл 08:00-17:00 цаг байхаар тогтоосон захирамж гаргажээ.

Ажлын цагийн хуваарь зохицуулалт хийх нийслэлийн төр, захиргааны байгууллагуудын жагсаалт:

№	Байгууллага
1	Нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын алба
2	Нийслэл, дүүрэг (хороо)-ийн Засаг даргын Тамгын газар
3	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, харьяа газар
4	Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг
5	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар (хуулийн этгээд, байгууллага)

ALISON & KATE PARTNERS

Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
5-р хороо, Pearl tower А блок 902 тоот
Web: www.akp.mn
E-mail: contact@akp.mn
Tel: 7704-1414, 9511-3680